



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймэг, Улаангом сум,

Ө.Бадрахын гудамж

Утас: 7045-3317, Факс: (976)7045-3317,

E-mail: uve@audit.gov.mn

АДХЗ.11.Х5 № 408
Танай _____ -ны № _____ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТЫН НЭГДСЭН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Я.САМБУУНЯМ ТАНДАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” сэдэвт аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт ² хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.БАТСУУРЬ



02002 0994

موریو سلكلیسر قىزى مەنگو ئامى سەلمە مە شەكەر



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН
2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛД
ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТ

АУДИТЫН КОД: УВА-2023/12-19-НА-НА

УЛААНГОМ ХОТ
2023 ОН



**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2025 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 43

Улаангом

┌ Аудитын тайлан баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.2 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх" сэдэвт аудитын тайланг (УВА-2023/12-19-НА-НА) хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Үндэсний аудитын газарт хүргүүлсүгэй.
3. Аймгийн хурлаар дэмжигдсэн саналуудын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер М.Бат-Амгалан, ахлах аудитор Т.Намжил, Б.Авирмэд нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200100307



Агуулга	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4-5
Товчирсон үгийн тайлал	6
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7-8

НЭГ. ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ УРТ БОЛОН ДҮНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ, ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДСАН
БАЙНА.....9-10

ХОЁР. ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ 11
Ул хөдлөх хөрөнгийн татварын орлогыг 150.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.....11-12

ГУРАВ. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ САНАЛ..... 13
Санал: 1. Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд батлагдсан зураг төсөвгүй, холбогдох зөвшөөрөлгүй 2 төсөл, арга хэмжээг нийт 1,106.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.....13-14
Санал: 2. Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд нийцээгүй 3 төсөл, арга хэмжээг нийт 170.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.....14-15

ДӨРӨВ. ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ16
Санал 1: Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хууль тогтоомжийн хүрээнд гаргаснаар орон нутгийн төсөвт 811.9 сая төгрөг төвлөрүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх боломж байна.....16-18
Санал:2. Сумдын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй суудлын авто машинаас бусад тээврийн хэрэгслийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах замаар төсвийн үр ашгийг дээшлүүлэх боломж байна.....19-20

ДҮГНЭЛТ.....21



Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 09 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/03 дугаар тушаалын дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилго

Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж аймгийн ИТХ-д хүргүүлэхэд аудитын зорилго чиглэсэн. Үүнд:

- Төсвийн төсөл нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэх
- Орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлэх боломж байгаа эсэх
- Орон нутгийн төсвийн төсөлд тусгасан зардлыг бууруулах боломж байгаа эсэх
- Орон нутгийн төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх боломж байгаа эсэх

Аудитын явцад АДБОУС, нийгээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дараах хууль, эрх зүйн актыг аудитын гол шалгуур үзүүлэлтээр эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Татварын багц хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэр, нэгж түүний удирдлагын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Ул хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль
- Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”

Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт



**Аудитын хамарсан
Хүрээ**

- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”

- Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар батлагдсан “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”

- Холбогдох бусад хууль, журам, заавар

Аудитыг аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар, сумдын Эмийн эргэлтийн сан, Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар болон холбогдох бусад газруудыг хамруулан 2024 оны төсвийн төслийн хүрээнд гүйцэтгэлээ.

**Аудитын бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Намжил, Б.Авирмэд, аудитор Ч.Мөнхтогтох, Т.Золгоо, Т.Амармэнд, Р.Аюуш, Б.Одгэрэл, Б.Нямбуу нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСАЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЭЭС	Эмийн эргэлтийн сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ОНХС	Орон нутгийн хөлжлийн сан
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ИЗХОТАХ	Их засвар, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ
ЗСХО	Замын сангийн хөрөнгө оруулалт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтад "... Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх" гэж заасны дагуу орон нутгийн 2024 оны төсвийн төсөлтэй танилцаж, орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал, дүгнэлтийг боловсруулсан.

Орон нутгийн 2024 оны төсвийн төсөл, 2025, 2026 оны төсвийн төсөөллийг аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 1/1372 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж, 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1/1958 дугаар албан бичгээр Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Улсын Их Хурлаас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон бусад дагагдах хуулиудыг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан байна. Ингэхдээ Монгол улсын 2024 оны төсвийн бодлогын онцлог 10 арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

1. Шинэ сэргэлтийн бодлого – Хог, хөдөөгийн сэргэлт.
2. Төрийн албан хаагчдын цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх.
3. Ахмадуудын тэтгэврийг нэмэгдүүлж, эдийн засгийн баталгааг хангах.
4. Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэх.
5. Багш ажилчдын нийгмийн баталгааг сайжруулах болон багш бэлтгэхтэй холбоотой бодлого, арга хэмжээний зардлыг тусгах.
6. Уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхэд татварын бодлогын дэмжлэг үзүүлэх.
7. Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, үнэт цаасны зах зээлийг татварын бодлогоор дэмжих.
8. Малчид орлолын, НӨАТ, малын тоо толгойн албан татвар тайлан боловсруулах, тушаах үүргээс чөлөөлөх, НӨАТ суутган төлөгч болох шаардлагагүй болгох замаар татварын орчныг хялбаршуулан, малын гаралтай түүхий эдийн бүртгэлийг сайжруулж, боловсруулах үйлдвэрүүдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж дэмжлэг үзүүлэх.
9. Хөгжилд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалт.
10. Байгалийн баялгийн өгөөжийг орон нутгийн хөгжилд чиглүүлэх.

Төсвийн хууль тогтоомж батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурал, Засгийн газраас 2024 онд баримталсан төсвийн бодлого, чиглэлийг орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд тусган боловсруулж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, баталсан төсвийг хэрэгжүүлэхэд баримтлах 5 чиглэлийг Сангийн яамнаас ирүүлсэн байна. Үүнд:



- Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар 9 заалт
- Төсвийн орлогын талаар 2 заалт
- Төсвийн зарлагын талаар 5 заалт
- Орон нутгийн хөгжлийн сан
- Орон нутгийн үр дүнгийн үзүүлэлтийг сайжруулах

Увс аймаг дахь Төрийн аудитын газар хууль, журамд заасны дагуу Орон нутгийн 2024 оны төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар бодитой хэрэгжих боломжтой дараах саналгуудыг дэвшүүлж байна.



**БҮЛЭГ: 1. ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ, ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДСАН БАЙНА.**

Увс аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, "Алсын хараа-2050", Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан байна.

Ингэхдээ Увс аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд аймгийн ИТХ, сүм, байгууллага, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, иргэдээс ирүүлсэн саналыг нэгтгэн эрэмбэлэн тусгасан байна. Үнд: Хөрөнгө оруулалт, засвар, тоног төхөөрөмжтэй холбоотой нийт 157 санал ирснээс 62 санал нь журамд заасан хугацаанд ирж 2024 оны жилийн ажлын төлөвлөгөөнд эрэмбэлэгдэн, төлөвлөгдөж Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргэгдэн хянагдсан байна. Хөтөлбөр арга хэмжээтэй холбоотой 144 санал ирүүлсэн байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт "Аймаг, нийслэлийн Засаг даргын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг", 9.10.1 дэх заалтад "Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх", 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт "Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна", 6.10.4 дэх заалтад "Орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх" гэж заасны дагуу аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө, орон нутгийн төсвийн төслийг боловсруулсан байна.

Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээ нь улс, орон нутгийн төсөвт дараах байдлаар тусгагдсан байна.

№	Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээ		Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ	
	Санхүүжүүлэх эх үүсвэр	Хөтөлбөрийн тоо	Тусгагдсан	Орон нутгийн төсөвт
1	Улсын төсвөөс санхүүжих	57	57	
2	Орон нутгийн хөгжлийн сан	39	39	
3	Их засвар хөрөнгө оруулалт	30		30
4	Замын сангийн хөрөнгө оруулалт	7		7
5	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	2		2
6	Хөтөлбөр төсөл, арга хэмжээ	6		6
Нийт		141	96	45

Эх сурвалж: Увс аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл, Орон нутгийн 2024 оны төсвийн төсөл



Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ нь Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй дараах байдлаар үйлдсэн байна.

№	Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр		Хэрэгжиж дууссан	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээтэй үйлдсэн эсэх
	Бодлого	Ерөнхий хөтөлбөрийн тоо		
1	Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	1	1	
2	Хүний хөгжлийн бодлого	6		6
3	Эдийн засгийн бодлого	4		4
4	Засаглалын бодлого	5		5
5	Ногоон хөгжлийн бодлого	7		7
6	Бүс, сүм, орон нутгийн хөгжлийн бодлого	2		2
Дүн		25	1	24

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, орон нутгийн 2024 оны төсвийн төсөл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ нь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй дараах байдлаар үйлдсэн байна.

№	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээтэй үйлдсэн
	Бодлого	Ерөнхий хөтөлбөрийн тоо	
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	5	5
2	Хүний хөгжил	7	7
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	6	6
4	Эдийн засаг	6	6
5	Засаглал	6	6
6	Ногоон хөгжил	4	4
7	Амар тайван, аюулгүй нийгэм	5	5
8	Бүс, сүм, орон нутгийн хөгжил	3	3
Дүн		42	42

Эх сурвалж: Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Орон нутгийн 2024 оны төсвийн төсөл



БҮЛЭГ: 2. ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

Орон нутгийн 2024 оны зардлыг санхүүжүүлэх эх үсвэрийг 69,701.1 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Дээрх эх үсвэрийг төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 18.3 сая, орон нутгийн орлогоос 20,696.7 сая, санхүүгийн дэмжлэгээр 34,144.2 сая, урьд оны үлдэгдлээс 734.6 сая, Орон нутгийн хөлжлийн сангаас 14,107.3 сая төгрөгөөр бүрдүүлэхээр тооцсон байна.

Орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх дараах саналыг гаргаж байна. Үнд:

Ул хөдлөх хөрөнгийн татварын орлогыг 150.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсэгт “Сум дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.8.16 дахь заалтад “Ул хөдлөх хөрөнгийн албан татвар” гэж заасан байна.

Сангийн яамнаас ирүүлсэн 2024 оны төсвийн суурь орлогод үл хөдлөх хөрөнгийн албан татвар орлогыг 530.0 сая төгрөгөөр тусгасан байна.

Ул хөдлөх хөрөнгийн албан татварын 2020-2023 оны орлогын гүйцэтгэл, татвар төлөгчдийн тоог хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Огноо	Ул хөдлөх хөрөнгийн албан татвар		/сая.төг/
	Үзүүлэлт	Татвар төлөгчийн тоо	
2020 он	Төлөвлөгөө	807	461.0
	Гүйцэтгэл		424.5
	Төлөвлөгөө		500.0
2021 он	Гүйцэтгэл	882	436.2
	Төлөвлөгөө		500.0
	Гүйцэтгэл		381.8
2022 он	Төлөвлөгөө	895	483.8
	Гүйцэтгэл 2023.10.31-ний байдлаар		361.8
	Хүлээгдэж байгаа гүйцэтгэл		410.6

Эх сурвалж: Аймгийн Татварын хэлтсийн судалгаа

Ул хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Ул хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан 0.6-2.0 хувиар тооцож ногдуулна” гэж заасны дагуу аймгийн ИТХ-ын 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 1/06 дугаар тогтоолоор үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг 0.6 хувь байхаар тогтоосон байна.

Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг үл хөрөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, хөрөнгийн даатгалд



даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр тус тус тодорхойлно” гэж заасан байна. Улсын бүртгэлийн хэлтсээс ирүүлсэн судалгаанд суурилган үл хөдлөх хөрөнгийн албан татварыг тооцоолж үзэхэд дараах байдалтай байна.

Огноо	Үл хөдлөх хөрөнгийн судалгаа			/сая.төг/
	Улсын бүртгэлд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн тоо (Үйлдвэр үйлчилгээний зориулалттай/	Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүн	Татварын хувь хэмжээ /0.6%/	
2023 он	1774	142,531.8	855.2	

Эх сурвалж: Улсын бүртгэлийн хэлтэс

Аймгийн хэмжээнд Улсын бүртгэлд бүртгэгдсэн үйлдвэр үйлчилгээний зориулалттай 142,531.8 сая төгрөгийн үнийн дүнтэй 1774 үл хөдлөх хөрөнгө байгааг аймгийн ИТХ-ын тогтоосон 0.6 хувиар тооцоход 855.2 сая төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого төвлөрөхөөр байна. Татварын халтгастай тулгахад орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд тусгаж ирүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогыг 150.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 680.5 сая төгрөгийг төвлөрүүлэх боломж байна.



БҮЛЭГ: 3. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БҮҮРҮҮЛЭХ САНАЛ

Орон нутгийн 2024 оны төсвийн нийт зарлагыг 69,701.1 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2023 оноос 19,941.3 сая төгрөгөөр буюу 40.1 хувиар өссөн байна.

Төсвийн нийт зарлага өсөхөд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 7,480.1 сая, НДШ-ийн зардал 934.0 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,736.9 сая, хөрөнгийн зардал 5,526.2 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна. Үүнд:

- Төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэлтэй холбоотой цалингийн зардал өссөн
- Дугааны тариф нэмэгдсэн
- Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр 2,783.3 сая, их засварын зардал 3,319.8 сая төгрөгөөр өссөн байна.

Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд урсгал зардал 50,219.3 сая төгрөг буюу 72 хувь, хөрөнгийн зардал 19,481.8 сая төгрөг буюу 28 хувийг эзэлж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгийн зардлын төлөвлөлтийг эх үүсвэрээр нь авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Их засвар, хөрөнгө оруулалтын 3,801.2 сая төгрөгийн 30 төсөл, арга хэмжээ
- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 6,368.4 сая төгрөгийн 39 төсөл, арга хэмжээ
- Аймгийн Замын сангийн 1,573.3 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 60.5 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ
- Хөтөлбөр төсөл арга хэмжээнд 593.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ

Санал: 1. Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд багтагдсан зураг төсөвлүй, холбогдох зөвшөөрөлгүй 2 төсөл, арга хэмжээг нийт 1,106.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.3 дахь заалтад “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь багтагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”, 13.5 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушавлаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аймаг, нийслэлийн түвшинд дараах нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ”, 4.1.3-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үнэлгээтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон



Байх” гэж заасан байхад батлагдсан зураг төсөвгүй, холбогдох зөвшөөрөл дутуу, төсөвлөлтийн шаардлага хангаагүй 2 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төсөвлөсөн байна. Үнд:

/сая.төг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Эх үүсвэр	Төсөвт өртөг	2024 онд санхүүж их дүн	Тайлбар
1	“Тэмүүлэл” хөдөлмөр амралтын зуслангийн засвар, тоног төхөөрөмж /Баруунтуруун сум/	ИЗХОТАХ	400.0	400.0	Зураг төсөвгүй
2	Улаангом сумын 5-р багийн хатуу хучилттай авто зам /Улаангом сум 5-р баг, Эрдмийн эхлэл сургуулийн урд засмал замын үргэлжлүүлэх/	ЗСХО	706.7	706.7	Зураг төсөвгүй
		Дүн	1106.7	1106.7	

Эх сурвалж: Орон нутгийн 2024 оны төсвийн төсөв

Дээрх батлагдсан зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй ажлуудыг хасах саналтай байна.

Санал: 2. Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд нийцээгүй 3 төсөл, арга хэмжээг нийт 170.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2-д “Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэж заажээ. Үнд:

- ❖ 4.2.1.Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим Технологи;
- ❖ 4.2.2.Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;
- ❖ 4.2.3.Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах;
- ❖ 4.2.4.Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;
- ❖ 4.2.5.Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх), зураг төсөв боловсруулах;
- ❖ 4.2.6.Аймагийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үйлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх;
- ❖ 4.2.7.Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт;
- ❖ 4.2.8.Ажлын байр бий болгох.



Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд журмын дээрх заалтад нийцээгүй дараах төсөл, арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Эх үүсвэр	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
1	Шүүхийн шийдвэрийн дагуу "Алтан үе ахмадын сувилал"-ын ажлын барьцаа 5 хувь /Түргэн сүм, Цүнхэг амралт/	ОНХС	20.0	20.0
2	Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх /ХБХБГ/	ОНХС	50.0	50.0
3	6 айлын 1 орон сууц барилгын материал /Давст, Боршоо боомт/	ОНХС	100.0	100.0
Дүн			170.0	170.0

/сая.төгрөг/

Эх сурвалж: Орон нутгийн 2024 оны төсвийн төсөв

Журамд нийцээгүй дээрх ажлуудыг ОНХС-ийн эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжгүй байна.



БҮЛЭГ: 4. ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ

Санал 1: Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хууль тогтоомжийн хүрээнд гаргаснаар орон нутгийн төсөвт 811.9 сая төгрөг төвлөрүүлж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх боломж байна.

Манай улсад 1994-2004 онд НУБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр 17 аймгийн 285 суманд Эмийн эргэлтийн сан байгуулагдсан байна. ЭЭС-ийн үйл ажиллагаанд Эрүүл мэндийн сайдын 2011 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 297 тоот тушаалаар баталсан “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-ыг мөрдөн ажиллаж байна.

Эмийн эргэлтийн сангийн ажиллах журмын 1.2-д “Сумын ЭЭС нь орон нутгийн өмчид суурилсан хуулийн этгээд байна”, 3.1-д “ЭЭС-ийн хөрөнгө нь орон нутгийн өмч, хамт олны хандив, гадаадын байгууллагын тусламж, өөрийн үйл ажиллагааны орлого болон бусад эх үүсвэрээс бүрдэнэ” гэж заасан байна.

Сумдын Эмийн эргэлтийн сангийн хөрөнгө, авлага, өр төлбөр 2023 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар дараах байдалтай байна.

№	Сумдын нэр	Мөнгөн хөрөнгө	Авлага	Эм, эмнэлгийн хэрэгсэл	Үндсэн хөрөнгийн дүн	Өглөг
1	Баруунгуруун	617,390	9,147,955	19,351,325	9,690,700	8,614,746
2	Бөхмөрөн	1,539,145	3,978,870	32,129,565	8,567,700	0
3	Давст	0	0	0	0	0
4	Завхан	19,901,586	23,394,589	45,953,955	4,594,030	40,342,405
5	Зүүнговь	9,832,466	25,591,715	71,863,212	2,489,773	32,345,174
6	Зүүнхангай	164,635	16,847,464	67,222,675	10,795,600	36,898,426
7	Мяргын	42,261	19,764,590	29,655,492	23,454,000	14,583,163
8	Наранбулаг	541,819	6,788,542	25,620,000	11,876,278	7,510,580
9	Өлгий	232,797	24,505,309	23,790,420	1,606,582	21,585,064
10	Өмнөговь	4,057,365	7,000,000	6,442,817	95,650	8,300,000
11	Өндөрхангай	837,183	15,661,588	2,503,196	12,884,760	10,296,777
12	Сэлэл	50,514,957	24,624,020	47,770,990	3,788,484	0
13	Тармалан	711,822	6,992,694	34,920,526	17,737,100	0
14	Түргэн	9,544,454	41,026,869	50,282,693	3,909,900	19,414,973
15	Тэс	907,298	45,939,500	32,437,684	5,198,000	45,939,500
16	Ховд	185,456	15,343,031	19,706,626	13,833,900	27,070,156
17	Хяргас	4,135,302	24,144,740	24,594,552	5,570,000	9,300,000
18	Цагаанхайрхан	0	0	22,501,076	15,408,000	0
	Нийт дүн	103,765,958	310,651,476	556,748,803	161,500,456	282,200,966

Эх сурвалж: Сумдын Засаг дарга, ЭМГ-ийн судалгаа

Дээрх судалгаанаас харахад сумдын ЭЭС-ийн бэлэн мөнгө, авлага, өглөг, эм, эмнэлгийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө харилцан адилгүй, ихэнх сумдын ЭЭС нь “Сум багийн түвшинд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг чанар,



хүртээмжтэй хүргэх, зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийг тогтвортой байлгах” суурь зарчимд нийцэж үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болсон байна. Тухайлбал: Сагил, Завхан сумдын ЭЭС бэлэн мөнгөний үлдэгдэл их байхад зарим сум үлдэгдэлгүй болсон, Зүүнговь, Зүүнхангай, Завхан сумдын ЭЭС эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэл их байхад зарим суманд бараг үлдэгдэлгүй болсон байна. Мөн авлага, өглөг нь сум бүрд харилцан адилгүй, авлага нь найдвартай авлага эсэх нь тодорхойгүй байна.

Сагил, Тариалан, Өлгий гэсэн 3 сумаас бусад бүх сумуудад хувийн эмийн сан үйл ажиллагаа явуулж байгаа нь сумдын ЭЭС-ийн үйл ажиллагаа харилцан адилгүй байгаад нөлөөлж байна. Мөн Эмийн эргэлтийн санг мөргөжил болон санхүүгийн удирдлагаар хангах үүрэг бүхий удирдах зөвлөл, сумын ЭЭС-ийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий хяналтын зөвлөл болон эрх бүхий байгууллагын хяналт, хариуцлага, уялдаа холбоо сул байгааг харуулж байна.

Сумдын ЭЭС-ийн үйл ажиллагаатай холбоотой аймгийн ИТХ-аас шийдвэр гаргаагүй байна.

Аудитын хүрээнд Эрүүл мэндийн газраас судалгаа авахад Давст, Өндөрхангай, Цагаанхайрхан сумдын ЭЭС хаалттай эмийн сан хэлбэрт шилжсэн тухай мэдээлэл ирүүлсэн.

Иймд аудитын явцад дээрх 3 суманд очиж ажиллахад дараах байдалтай байна. Үүнд:

- ❖ Өндөрхангай сумын Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/65 дугаар “Сумын эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг хаалттай болгох тухай” захирамж гарч ЭЭС-ийн эмийн үлдэгдэлд тооллого хийж хаалттай эмийн сангийн хэлбэрт шилжүүлсэн байна. Ингэснээр тухайн сумын ЭЭС ард иргэдэд үйлчилгээ үзүүлэхгүй зөвхөн сумын Эрүүл мэндийн төвийн эмийг нийлүүлэх байдлаар үйл ажиллагаа явуулж байна. Тухайн сумын ЭЭС-ийн 2 данс байх бөгөөд 1 дансанд Засаг дарга, 1 дансанд нь ЭМТ-ийн эрхлэгч гарын үсэг зурж байгаа нь хууль, журамд нийцэхгүй байна. Мөн ЭЭС-ийн үйл ажиллагаа явуулж байсан барилгыг хувь иргэнд түрээсэлсэн байна.
- ❖ Цагаанхайрхан сумын хувьд 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдөр ямар нэгэн шийдвэргүйгээр ЭЭС-ийн эмийн үлдэгдэлд тооллого хийж хаалттай эмийн сан хэлбэрт шилжсэн байна. Ингэхдээ ЭЭС-ийн дансыг хааж үлдэгдэл 12.9 сая төгрөгөөр эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан байх бөгөөд тухайн үеийн тооллогоор 22.5 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг сумын Эрүүл мэндийн төвд шилжүүлсэн байна. ЭЭС-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан лангуу 2 ширхэг, тавиур 2 ширхэг, түмбүүшик 1 ширхэг, суурин компьютер 1 ширхэг, бар код уншигч 1 ширхэг зэрэг хөрөнгийг хувийн эмийн санд шилтүүлж байна.
- ❖ Давст сумын хувьд 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдөр ямар нэгэн шийдвэргүйгээр ЭЭС-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэлд тооллого хийхгүйгээр ЭЭС-ийн дансыг хааж үлдэгдэл 4.3 сая төгрөгөөр эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан байх бөгөөд ЭЭС-ийн үйл ажиллагааг эмийн санчаар ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан иргэн хувийн эмийн сан хэлбэрээр сумын Эрүүл мэндийн төв болон иргэдэд үйлчлэх байдлаар ажиллуулж байна. Гэхдээ сумын Эрүүл мэндийн төвд олгосон эмийн үнийг аваагүй байна.

Дээрх 3 сумын ЭЭС-ийн жишээг харахад эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр хаалттай эмийн сан хэлбэрт шилжихдээ 3 өөр янзын арга зам ашиглаж байгаа нь орон нутгийн өмч хөрөнгө зориулалт бусаар, хяналтгүйгээр, үргүй зарцуулагдах, хууль, тогтоомжийн хэрэгжилт алдагдах эрсдэлийг үүсгэж байна. Түүнчлэн бусад сумуудын ЭЭС-ийн хувьд ч аудитын явцад уулзалт ярилцлага хийж, судалгаа авахад сумдын ЭЭС-ийн үйл ажиллагааг цаашид нэг чиглэлд оруулах шаардлагатай байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талгаар иргэдийн



Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй", 2.3-д "Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах.", 2.4-д "Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих", 81 дүгээр зүйлийн 1-д "Орон нутгийн өмчийг хувьчлах арга, хэлбэр, журмыг энэ хуулийн зургаадугаар бүлэгт заасныг удирдлага болгон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно", Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 35.1.12 дахь заалтад "Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх" гэж заасан байна.

Аймгийн ИТХ-аас хуулийн хүрээнд шийдвэр гаргаснаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 3-д "Орон нутгийн өмчийн хувьчлалын орлогыг тухайн орон нутгийн төсөвт оруулна" гэж заасны дагуу 2023 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар тооцож үзэхэд сумдын ЭЭС-ийн үлдэгдэл бэлэн мөнгө 103.7 сая, эм эмнэлгийн хэрэгсэл 556.7 сая, үндсэн хөрөнгө 151.5 сая, нийт 811.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх боломж байна.



Санал:2. Сумдын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй суудлын авто машинаас бусад тээврийн хэрэгслийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах замаар төсвийн үр ашгийг дээшлүүлэх боломж байна.

Сумдын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй суудлын автомашинаас бусад Ковш, Хөдөө аж ахуйн зориулалттай трактор, техник хэрэгсэл, ниверсал трактор, хогны, усны, бохирын, мал угаалгын зэрэг нийт 2,697.3 сая төгрөгийн өртөгтэй 49 тээврийн хэрэгсэл байна. Судалгаагаар харуулбал:

Д/д	Сумдын нэр	Авто тээврийн хэрэгсэл	Эх үүсвэр	Бүртгэл тусгасан өгнөө	Балансын үнэ /төгрөг/	Одоо ашиглаж байгаа хэлбэр	Ашиглалттай холбоотой орсон орлого /сая.төгрөг/	Намралт тайлбар
1	Баярчулуун	Хогны машин Бохирын машин Ариутгалын машин Ковш	ОНХС ОНХС ОНХС ОНХС	2018.12.31 2020.11.01 2022.08.08 2022.03.17	11,800,000 40,000,000 43,800,000 46,800,000	ашиглахгүй ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа тохиромжтой өмчлөд ашиглаж	0 0 0 0	0 өмчлөрсөн 0 0
2	Баянхонгор	Хогны машин ХАА-н трактор	АОНХС Уул уурхай	2021.11.10 2019.07.01	29,900,000 30,000,000	байгаа түрээслүүлсэн	0	2023 оны 9 сардаас түрээслэж эхэлсэн
3	Давст	Бохирын машин 2 үйлдэлт трактор Хогны машин ДЛК машин	ОНХС ОНХС ОНХС ОНХС	2021.07.01 2020.12.25 2021.06.28 2022.12.30	47,880,000 69,000,000 39,900,000 44,800,000	ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглахгүй	0 3,185,000 390,000	0
4	Завхан	Хог зөөврийн машин Хогны машин ДЛК машин Дорнод	ОНХС СОНХС ОНХС Улсын төсөв	2013.09.30 2021.12.31 2023.01.01 2013.12.25	17,930,000 34,000,000 43,800,000 27,000,000	ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа	0	0
5	Зүүнговь	Суваги явга Хогны машин	Улсын төсөв ОНХС	2022.12.31 2017.07.02	39,000,000 18,500,000	ашиглаж байгаа өмчлөрсөн	0	өмчлөрсөн
6	Зүүнхангай	Усны машин 2 үйлдэлт трактор Увэрсаал трактор Нундгай,Мургул	ОНХС ОНХС ОНХС ОНХС	2014.06.30 2018.11.16 2021.05.10 2022.04.19	2,800,000 45,000,000 115,601,700 34,999,000	өмчлөрсөн өмчлөрсөн түрээслэж байгаа ашиглаж байгаа	0 5,000,000	2023 оны 8 сар хүртэл сумын төвийн нэгдсэн байгууллагийг үеэлсэн Одоо бол өмчлөрсөн
7	Мөрөн	Хогны машин Хогны машин Ковш	ОНХС ОНХС ОНХС	2023 2020	59,800,000 90,000,000	эхлээгүй ашиглаж байгаа	0	орлогоороо баянзны хийдэг
8	Наранбулаг	Хогны машин Ковш	АОНХС АОНХС	2022.11.23	45,000,000	ашиглаж байгаа	0	0
9	Өлгий	Хогны машин	АОНХС	2022.11.23	6,500,000	Сумын тэв гудамж талбайн эргэн тойрны хойр цөөрөгж ачих	0	0
10	Өмнөговь	Дамьжиргала цагаан ХАА-н трактор	СОНХС ТА-1 төсөлөөс	2021.12.24 2009.01.01	2,800,000	Ашиглах боломжгүй	0	0
11	Өндөрслэнгай	Хогны машин ХАА-н трактор Усны машин Бохирын машин ХАА-н трактор ХАА-н трактор Хогны машин	АОНХС УТХО ОНХС АОНХС АОНХС СОНХС АОНХС	2023.09.13 2021.12.24 2022.12.01 2021.12.01 2021.01.29 2021.12.30 2020.12.31	56,980,000 115,600,000 39,900,000 48,900,000 59,500,000 33,000,000 39,900,000	ашиглаж байгаа эхлээгүй байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа	0 1,470,000 1,700,000	0
12	Сэлэнгэ	Хогны машин ДЛК машин	АОНХС ОНХС	2023.10.07	40,000,000	ашиглаж байгаа	0	0
13	Төрмөговь	ХАА-н трактор 2 үйлдэлт трактор	АОНХС АОНХС	2010.12.30 2021.11.31	11,000,000 160,000,000	байр ва ашиглаж байгаа	12,000,000	өмчлөх санхүүгийн өмчлөх байр
14	Түргэн	2 үйлдэлт трактор Трактор өлбөрүмөр Улсын төсөв	ОНХС ОНХС Улсын төсөв	2020.04.27 2022.08.11 2020.12.31	148,800,000 99,200,000 39,000,000	ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа	17,114,200 3,000,000	0
15	Төв	Хогны машин 2 үйлдэлт трактор	ОНХС ОНХС	2022 2019	44,800,000 70,000,000	ашиглаж байгаа	330,000	0
16	Ховд	Ариутгалын машин 2 үйлдэлт трактор ДЛК машин Портёр	УОКЖинсг ОНХС ОНХС ОНХС	2022 2014 2022 2017	160,000,000 78,000,000 63,888,000 17,500,000	ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа	0	0
17	Ховд	Хогны машин Усны машин Увэрсаал трактор Бохирын машин ЗД-н цагаан трактор	ОНХС УТХО УТХО АОНХС ОНХС	2020.12.31 2021.10.01 2021.10.01 2020.12.31 2014.12.30	90,800,000 47,360,000 116,050,000 40,000,000 90,800,000	ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа	0	0
18	Цагаанхайрхан	Хогны машин Увэрсаал трактор Бохирын машин ЗД-н цагаан трактор	ОНХС УТХО УТХО АОНХС	2020.12.31 2021.10.01 2021.10.01 2020.12.31	47,360,000 116,050,000 40,000,000 90,800,000	ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа ашиглаж байгаа	0	0
	Нийт дүн				2,697,296,700		46,149,200	

Эх сурвалж: Сумдын ЗДТГ-аас өгсөн судалгаа



Дээрх судалгаанаас харахад Улсын төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөс гадна дийлэнх хувь нь аймгийн болон сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэгдсэн үндсэн хөрөнгө байна.

Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-д

- **Журмын 4.1-д "Аймаг, нийслэлийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ", 4.1.6-д "Аймаг, нийслэлийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргасан байх", 4.1.7-д ОНХС-ийн хөрөнгөөр бий болох хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний өмчлөл, цаашдын ашиглалтын урсгал зардал, шинээр бий болох орон нутаг өөрөө хариуцах",**
- **Журмын 4.3-д "Сум, дүүргийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ", 4.3.7-д "Сум, дүүргийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах", 4.3.8-д "ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болох хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний өмчлөл, цаашдын ашиглалтын урсгал зардал, шинээр бий болох орон тоог орон нутаг өөрөө хариуцах" гэж тус тус заасан байна.**

Гэтэл тухайн хөрөнгүүдийг анх төсөвт тусгаж бэлтгэхдээ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг хэрхэн шийдвэрлэхийг тооцоогүй, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх судалгаа дүгнэлт гаргаагүй байна. Энэ нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн өмчлөл, цаашдын ашиглалтын урсгал зардал, шинээр бий болох орон тоог орон нутаг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгээд байна.

Аудитын хүрээнд зарим сумдад очиж ажиллахад сум орон нутгийн удирдлагын зүгээс тухайн бүртгэлтэй техник хэрэгслийг суманд хариуцан ажиллуулах хүн байхгүй, эвдэрсэн тохиолдолд сэлбэг хэрэгсэл авах төсөв, санхүү байхгүй, түрээслэх эрх зүйн зохицуулалт, зөвлөмж чиглэл тодорхойгүй, сум, орон нутагт байнга ашиглах боломжгүй, хүйтний улиралд байлгах грав байхгүй, ихэнхдээ айлын хашаанд хадгалагдах байдалтай, зарим нь техникийг огт ашиглаж эхлээгүй, зарим нь жилд цөөхөн ашигладаг, зарим нь одоо болтол бичиг баримтгүй, номер дугаар аваагүй гэх мэт олон асуудал тулгарч байгаа талаар мэдээлэл өгсөн.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2-д "Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй", 2.1-д "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах", 2.2-д "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх", 78 дугаар зүйлийн 2-д "Хуульд өөрөөр заагаагүй бол Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 2.1-д "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах" гэж заасан эрхийн хүрээнд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлснээр төсвийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжирч, Төсвийн үр ашиг нэмэгдэх болможтой байна.



ДҮГНЭЛТ

Энэхүү аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, судалгаа шинжилгээнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн 2024 оны төсвийн төсөл нь аймгийн урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, жилгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байна.
2. Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, удирдамжийн дагуу 2024 оны төсвийн төслийг боловсруулсан байна.
3. Орон нутгийн 2024 оны төсвийн нийт зарлагыг 69,701.1 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2023 оны батлагдсан төсвөөс 19,941.3 сая төгрөгөөр буюу 40.1 хувиар өссөн байна.
4. Орон нутгийн төсвийн орлогыг 150.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
5. Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд батлагдсан зураг төсөвгүй, холбогдох зөвшөөрөл аваагүй 1,106.7 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ байна.
6. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд нийцээгүй 170.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ байна.

Хянасан: Аудитын менежер

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Аудитор


М.Бат-Амгалан
Т.Намжил
Б.Авирмэд
Ч.Мөнхтогтох
Р.Аюуш
Б.Одгэрэл
Т.Амармэнд
Т.Золтоо
Б.Нямбуу